



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/165

Хэрлэн сум

Цэрэг татлага зохисч байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны мн/124 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2024 оны н/54 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2024 оны 04 дүгээр сарын 19-өөс 2024 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хооронд явуулсугай.

2. Цэрэг татлагын товчоог дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Товчооны

дарга: Ж.Гантулга Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Орлогч

дарга: Л.Цэнддорж Цэргийн штабын дарга, Дэд хурандаа

Гишүүд:

Ж.Эрдэнэбат Онцгой байдлын газрын дарга, Хурандаа

Э.Жавхлантөгс Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа

О.Баярлхагва Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа

Л.Мэндбаяр Эрүүл мэндийн газрын дарга

О.Бадамсүрэн Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Ган-Эрдэнэ Насан туршийн суралцахуйн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Шүрэнцэцэг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч

Нарийн бичгийн

дарга: Г.Батгэрэл Цэргийн штабын Тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа

3. Цэрэг татлагын хуваарийг хавсралтаар баталсугай.

4. Цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн судалгааг үндэслэн эмчлэгдэн эдгэрэх боломжтой залуучуудын нэрсийн жагсаалтыг гарган эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр)-т, Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ын дагуу шинжилгээ, оношилгоог үндэслэн чанартай зохион байгуулахыг Нэгдсэн

2.

эмнэлэг (О.Бадамсүрэн)-д, цэргийн албанд татагдагчдын боловсролын түвшин тогтоох, бичиг үсэг үл мэдэгч иргэдийг албан бус сургалтад хамруулахыг Насан туршийн боловсролын "Гэгээрэл" төв (Г.Дашдаваа)-д, цэргийн албанд татагдагчдын гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан эсэхийг хянах, цэрэг тээвэрлэх автомашинд үзлэг хийх, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн Дэд хурандаа Э.Жавхлантөгс)-т, цэрэг татлагын байрны галын аюулгүй байдлыг хангах, цэрэг татлагын товчооны ажилд дэмжлэг үзүүлэхийг Онцгой байдлын газар (Хурандаа Ж.Эрдэнэбат)-т, цэргийн албанд татагдагчдын өргөдөл, материалыг хянаж, судалгаа гаргахыг Тагнуулын хэлтэс (Дэд хурандаа О.Баярлхагва)-т тус тус үүрэг болгосугай.

5.Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрд хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгах, тэдний бичиг баримтыг бүрдүүлэх, цусны бүлэг тогтоох, хэвлийн чанд авиан оношилгоо, шээсний шинжилгээг урьдчилан хийсэн байх, Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг ажиллах нөхцөл, хоол хүнсээр хангах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авч, тэднийг ажлын байранд зуучлах, цэргийн албанд татагдагчдыг үдэж мордуулах ажлыг сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулахыг сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

6.Хэрлэн сумын Соёлын төвийг түшиглэн аймгийн Цэрэг татлагын байрыг зааврын дагуу бэлтгэж, Цэрэг татлагын товчоо, зохион байгуулах бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг Хэрлэн сумын Засаг дарга М.Шүрэнцэцэгт даалгасугай.

7.Цэрэг татлагын үеэр батлан хамгаалах бодлого, зорилтыг сурталчлах өдөрлөг зохион байгуулах, Цэрэг татлагын товчооны гишүүдийг үүрэг даалгавар, мэдээллээр хангах, цэргийн албанд тэнцэгчдийн бичиг баримтыг бүрдүүлэх, цэргийн албанаас халагдагсдыг хүлээн авч, цэргийн бүртгэлд тусган, сумдын Засаг даргын Тамгын газрын нарт хүлээлгэн өгч, орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Л.Цэнддорж)-т даалгасугай.

8.Цэрэг татлагын товчоонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу хянан шийдвэрлэх, Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан хуульд заасан шаардлага хангасан залуучуудыг хугацаат цэргийн албанд татаж, 2024 оны 05 дугаар сарын 05-нд багтаан алба хаах цэргийн ангиудад хүлээлгэн өгч, 2024 оны 05 дугаар сарын 10-нд танилцуулахыг Цэрэг татлагын товчоо (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

A/165

2024 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Сум, багийн нэр	Үзлэгээр орох хүний тоо	Хяналтын тоо	Цэрэг татлагад орох газар	Үзлэгт бэлэн байх	
					Сар өдөр	Цаг
1.	Баянхутаг			Баянхутаг	04.19	09.00
2.	Галшар			Галшар	04.19	15.00
3.	Бор-Өндөр			Бор-Өндөр	04.20	10.00
4.	Дархан			Дархан	04.22	09.00
5.	Баянмөнх			Баянмөнх	04.22	14.00
6.	Дэлгэрхаан			Дэлгэрхаан	04.23	09.00
7.	ХБУлаан				04.23	09.00
8.	Цэнхэрмандал			Цэнхэрмандал	04.23	15.00
9.	Жаргалтхаан			Жаргалтхаан	04.24	09.00
10.	Мөрөн			Мөрөн	04.24	15.00
11.	Хэрлэн			Хэрлэн	04.28	09.00
12.	Өлзийт			Хэрлэн	04.29	09.00
13.	Өмнөдэлгэр					
14.	Гурванбаян					
15.	Батширээт					
16.	Биндэр					
17.	Баян-Адарга					
18.	Дадал					
19.	Норовлин					
20.	Батноров					
21.	Баян-Овоо					
22.	Бэрх					
	Нийт дүн					